



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 4/803

Улаанбаатар хот

Г
Журам батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ын 3.18 дахь заалт, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү журмыг 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхийг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал, аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтан нарт үүрэг болгосугай:
 - 3.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журмыг хэрэгжүүлэх зөвлөмжийг 2020 оны I улиралд багтаан боловсруулж, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газарт хүргүүлэхийг Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар /Ж.Мягмар/, Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/-т;
 - 3.2. Байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ хийх арга зүйн сургалтыг 2020 оны III улиралд багтаан үе шаттайгаар зохион байгуулахыг Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар /Ж.Мягмар/, Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/-д;
 - 3.3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлсэн үнэлгээний үр дүнг боловсролын салбарын мэдээллийн системээр цуглуулах, шинжилгээ хийх програм хангамжийг хөгжүүлэх шийдлийг 2020 оны I улиралд багтаан танилцуулахыг Мэдээллийн технологи, статистикийн хэлтэс /О.Дунжиннамдаг/-т;
 - 3.4. Журмыг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад танилцуулан, үнэлгээний багийг арга зүйгээр хангаж, хөндлөнгийн үнэлгээг үр дүнтэй зохион байгуулж байхыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайханд даалгасугай.

5. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2003 оны 321 дүгээр тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх тоон болон чанарын шалгуур үзүүлэлт”-ийг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ё.БААТАРБИЛЭГ



Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2019 оны 12 дугаар
сарын 17-ний өдрийн 2019 дугаар
тушаалтын хавсралт

**ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль /цаашид "цэцэрлэг, сургууль" гэх/-ийн үйл ажиллагааны чанар, үр дүнг үнэлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг үнэлэх үнэлгээ /цаашид "үнэлгээ" гэх/-ний зорилго нь байгууллагын менежмент, багшлах, суралцах үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулахад оршино.

1.3. Үнэлгээ нь тасралтгүй явагдах эргэх холбоо бүхий үйл явц бөгөөд тухайн байгууллага дэвшүүлсэн зорилгодоо хүрч буй эсэхийг тогтоож, цаашид сайжруулах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлно.

1.4. Үнэлгээ нь хууль тогтоомжид нийцсэн, ил тод, нээлттэй, шударга ёсны зарчимд тулгуурласан, албан ёсны тоо баримт, мэдээлэлд суурилсан, боловсролын харилцаанд оролцогч талуудын оролцоог хангасан, үнэлгээ, дүгнэлт нь бодитой, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон, нотлогдохуйц, хөндлөнгийн нөлөөлөлгүй байна.

1.5. Үнэлгээ нь өөрийн болон хөндлөнгийн гэсэн хэлбэртэй байна.

1.5.1. Өөрийн үнэлгээ гэж цэцэрлэг, сургууль дэвшүүлсэн зорилгодоо хүрч буй эсэх, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны чанар, нийцийг баримт нотолгоонд тулгуурлан хамтын оролцоотой үнэлж, байгууллагын түвшинд сайжруулах шаардлагатай асуудлыг илрүүлэх оношилгоог ойлгоно.

1.5.2. Хөндлөнгийн үнэлгээ гэж өөрийн үнэлгээ бодитой эсэхийг магадлан баталгаажуулах, тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад шаардагдах дэмжлэгийг тодорхойлох зорилгоор хөндлөнгийн байгууллагаас хийх үнэлгээг ойлгоно.

1.6. Өөрийн үнэлгээнд тулгуурлан хөндлөнгийн үнэлгээг зохион байгуулна.

1.7. Үнэлгээг тухайн байгууллагын бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт, удирдлагын шийдвэр, хичээл, сургалтын явц болон сургалтад хөтлөгдөж буй баримт бичиг, сургалтын чанар, үр дунд хийсэн дүн шинжилгээ, хичээл ажиглалтын тэмдэглэл, удирдлагын манлайлал, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн хамтын ажиллагаа, хуухдэд үзүүлэх үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хамаарах албан ёсны баримт мэдээлэлд тус тус үндэслэн хийнэ.

1.8. Үнэлгээ хийхэд энэ журмын хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлтийг баримтлах бөгөөд үнэлгээний үнэн зөв, бодит байдлыг үнэлгээний баг хариуцна.

1.9. Өөрийн үнэлгээг жил бүр, хөндлөнгийн үнэлгээг 3 жил тутам тус тус хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээг хугацаанаас нь өмнө хийж болно.

Хоёр. Өөрийн үнэлгээний зохион байгуулалт

2.1. Өөрийн үнэлгээг цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирлын тушаалаар томилсон үнэлгээний баг зохион байгуулна.

2.1.1. Цэцэрлэг, сургуулийн хэв шинж, багш, ажилтны тооноос хамаарч үнэлгээний баг 5-15 гишүүнтэй байна.

2.1.2. Үнэлгээний багийн бүрэлдэхүүнд цэцэрлэг, сургуулийн зөвлөл, заах аргын нэгдлийн ахлагч, багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл байна.

2.1.3. Үнэлгээний багийн бүрэлдэхүүнд ажиллах хүний тоо, төлөөлөл, багт ажиллах багш, ажилтны нэрийг хамт олны хурлаар хэлэлцэж тогтох бөгөөд хамт олны хуралд нийт багш, ажилтны 90-ээс доошгүй хувь нь оролцож, тэдний 80-аас доошгүй хувь нь хэлэлцэж буй асуудлыг дэмжсэн тохиолдолд шийдвэрийг хүчинтэйд тооцно.

2.1.4. Энэ журмын 2.1.3-т заасан хурлын шийдвэрт үндэслэн үнэлгээний багт ажиллах суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллийг суралцагчийн болон эцэг, эх, асран хамгаалагчийн зөвлөлийн хурлаас нэр дэвшүүлнэ.

2.1.5. Цэцэрлэг, сургуулийн хамт олны хурал болон энэ журмын 2.1.4-д заасан зөвлөлийн хурлын шийдвэрт тус тус үндэслэн үнэлгээний багийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал баталгаажуулна.

2.2. Үнэлгээний баг гишүүдийн ажлын чиг үүргийг тодорхойлж, өөрийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулан үе шаттай хэрэгжүүлнэ.

2.3. Үнэлгээний баг энэ журмын хавсралтаар баталсан шалгуурын дагуу холбогдох баримт, нотолгоо, мэдээлэл цуглуулах асуулга, ярилцлагад нийт багш, ажилтны 90-ээс доошгүй хувь, VII-XII ангийн суралцагчдын 80 хүртэл хувийг тус тус хамруулна.

2.3.1. Дотуур байрны үйлчилгээний талаар дотуур байранд амьдарч буй VII-XII ангийн суралцагчдаас асуулга авна.

2.4. Хичээл, үйл ажиллагааны зохион байгуулалтын шалгуур үзүүлэлтийг багшийн хичээлд ажиглалт хийх замаар үнэлэх бөгөөд 6 хүртэл бүлэгтэй цэцэрлэгийн багшийг 100 хувь, түүнээс дээш бүлэгтэй цэцэрлэгийн нийт багшийн 50 хувь, 10 хүртэл багштай сургуулийн багшийг 100 хувь, түүнээс дээш багштай сургуулийн нийт багшийн 20-30 хувийг тус тус хамруулна.

2.5. Багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч нь шалгуур үзүүлэлтийн дагуу асуулга /маягт/-ыг үнэн зөв, бодитой бөглөнө.

2.6. Үнэлгээний баг нь хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явц, хүүхэд хоцрогдолгуй суралцахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр сургалтын байгууллагаас эцэг эх, асран хамгаалагчдын дунд зохион байгуулдаг ажил, мэдээлэл, зөвлөгөө тэдгээрийн үр дүн, цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа болон шийдвэр гаргахад эцэг эх, асран хамгаалагч оролцох тэгш боломжоор хангагдсан байдлын талаар эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллийг цэцэрлэгт 30 хувь, сургуульд 10-20 хувийг тус тус хамруулан асуулга авна.

2.7. Суралцагч, эцэг эх, асран хамгаалагчаас мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг үнэлгээний багт ажиллаж байгаа суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл хариуцан зохион байгуулна.

2.8. Багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчаас цуглуулсан мэдээлэл, энэ журмын 2.4-т заасан хичээл, үйл ажиллагааны ажиглалт нь өөрийн үнэлгээний дүгнэлт гаргах, хөндлөнгийн үнэлгээний баталгаажуулалт хийх суурь мэдээлэл болно.

2.9. Багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчаас цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, шалгуур үзүүлэлт бүрийг үнэлж, тайлан боловсруулах, үр дүнг танилцуулах ажлыг энэ журмын 2.1-т заасан баг хариуцна.

2.10. Өөрийн үнэлгээ хийхэд 3-аас доошгүй сарын хугацаа зарцуулах бөгөөд жил бүрийн 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор дууссан байна.

2.11. Үнэлгээний багийн ажиллах нөхцөл боломжийг цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал бүрдүүлнэ.

Гурав. Хөндлөнгийн үнэлгээний зохион байгуулалт

3.1. Хөндлөнгийн үнэлгээг нутгийн захиргаа, мэргэжил, арга зүйн болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 3-5 хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэх бөгөөд багийн бүрэлдэхүүнийг аймаг, нийслэлийн боловсролын газрын даргын тушаалаар томилно.

3.2. Хөндлөнгийн үнэлгээнд тухайн хичээлийн жилд хамрагдах цэцэрлэг, сургуулийн нэrsийг аймаг, нийслэлийн боловсролын газрын даргын тушаалаар баталж, тухайн оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор тухайн цэцэрлэг, сургуульд тус тус мэдэгдэнэ.

3.3. Хөндлөнгийн үнэлгээнд хамрагдах мэдэгдэл хүлээн авсан цэцэрлэг, сургууль өөрийн үнэлгээний тайлан, энэ журмын хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлтийг хангасан болохыг нотлох баримт бичгийг тухайн оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн боловсролын газарт хэвлэмэл хэлбэрээр хургуулнэ.

3.4. Хөндлөнгийн үнэлгээний баг тухайн цэцэрлэг, сургууль дээр ажлын 5-аас илүүгүй хоног ажиллана.

3.5. Хөндлөнгийн үнэлгээг тухайн оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хийж дууссан байна.

3.6. Үнэлгээний баг нь өөрийн үнэлгээний тайлан, энэ журмын 1.7-д заасан баримт бичиг, материалтай танилцаж дүн шинжилгээ хийх, хичээл ажиглах, цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааны талаар сум, дүүргийн Засаг дарга, багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл болон цэцэрлэг, сургуулийн удирдлагын багтай уулзалт, ярилцлага хийх зэрэг ажлыг зохион байгуулна.

3.6.1. Хичээл, үйл ажиллагааны зохион байгуулалтын шалгуур үзүүлэлтийг үнэлэх ажиглалтад б 6 хүртэл бүлэгтэй цэцэрлэгийн нийт багшийн 50 хувь, түүнээс дээш бүлэгтэй цэцэрлэгийн нийт багшийн 30 хувь, 10 хүртэл багштай сургуулийн нийт багшийн 50 хувь, түүнээс дээш багштай сургуулийн нийт багшийн 10-20 хувийг тус тус хамруулна.

3.7. Сургалтын үр дүнг үнэлэхэд цэцэрлэгийн хүүхдийн хөгжлийн ахицын үнэлгээ, суралцагчийн сурлагын амжилтын хичээлийн жилийн эцэс, анги дэвших болон улсын шалгалтын дунд хийсэн шинжилгээ, Боловсролын үнэлгээний төвөөс үндэсний хэмжээнд зохион байгуулсан сургуульд бэлтгэгдсэн байдал, чанарын үнэлгээний судалгааг тус тус ашиглах бөгөөд шаардлагатай гэж үзвэл суралцагчдаас шалгалт авч болно.

3.8. Энэ журмын 3.6, 3.7-д заасан үйл ажиллагааны үр дүн нь хөндлөнгийн үнэлгээний дүгнэлт гаргах нотолгоо болно.

3.9. Хөндлөнгийн үнэлгээгээр тухайн цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааны онцлог, хичээл, сургалтын үр дүн, сайн туршлагыг тус тус илрүүлэн, үйлчилгээний чанар, үр ашгийг сайжруулахад нэн тэргүүнд анхаарах шаардлагатай асуудлыг тодорхойлно.

3.10. Хөндлөнгийн үнэлгээнд энэ журмын 5.4.2-д заасны дагуу дахин хамрагдах тохиолдолд цэцэрлэг, сургууль өмнө хийгдсэн хөндлөнгийн үнэлгээний үр дүнгээр анхаарал хандуулах шаардлагатай гэж үзсэн асуудлын хэрэгжилтийг үнэлгээ дахин хийхээс өмнө аймаг, нийслэлийн боловсролын газарт тайлагнана.

3.11. Хөндлөнгийн үнэлгээний баг нь энэ журмын 3.6, 3.7-д заасан баримт бичиг, материалаас гадна нэмэлт баримт бичиг, материалыг цэцэрлэг, сургуулиас шаардахгүй.

Дөрөв. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

4.1. Цэцэрлэгийн үйл ажиллагааг энэ журмын 1 дүгээр хавсралт, сургуулийн үйл ажиллагааг журмын 2 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлт үзүүлэлтээр тус тус үнэлнэ.

4.2. Энэ журмын хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлт бүрийг 3, 2, 1, 0 оноогоор дараах аргачлалыг баримтлан үнэлнэ:

4.2.1. тухайн шалгуур үзүүлэлтэд тусгагдсан бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны зохицуулалт, зохион байгуулалт бүрэн хийгдсэн, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ тогтмолжсон, бодит үр дүн гарсан бол 3 оноо;

4.2.2. тухайн шалгуур үзүүлэлтэд тусгагдсан бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны зохицуулалт, зохион байгуулалт хийгдсэн, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ тогтмолжоогүй, үр дүн тогтвортой биш бол 2 оноо;

4.2.3. тухайн шалгуур үзүүлэлтэд тусгагдсан бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны зохицуулалт, зохион байгуулалт хангалтгүй хийгдсэн, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ тодорхой бус, үр дүн гараагүй бол 1 оноо;

4.2.4. тухайн шалгуур үзүүлэлтэд тусгагдсан бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны зохицуулалт, зохион байгуулалт хийгдээгүй буюу зарим үйл ажиллагаа хийгдсэн ч үр дүнгүй бол 0 оноо.

4.3. Хичээл, үйл ажиллагааны зохион байгуулалтын шалгуурыг үнэлэхэд ажиглалтад хамрагдсан багш нарт өгсөн онооны арифметик дундажаар тооцно.

4.4. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаанд өгсөн нийт онооны нийлбэрийг хувьд шилжүүлж дараах үнэлгээ өгнө:

95 ба түүнээс дээш хувьтай бол "үлгэр жишээ үйл ажиллагаатай" ;

80-94 хувьтай бол "хэвийн үйл ажиллагаатай" ;

60-79 хувьтай бол "дундаж үйл ажиллагаатай" ;

0-59 хувьтай бол "дэмжлэг шаардлагатай".

Тав. Үнэлгээний тайлан, үр дүн танилцуулах

5.1. Энэ журмын 2.1, 3.1-т заасан үнэлгээний баг холбогдох баримт, нотолгоонд тулгуурлан үнэлгээний тайлан бичиж, үнэлгээний багийн гишүүдээр баталгаажуулна.

5.2. Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний тайланд цэцэрлэг, сургуулийн товч мэдээлэл, үнэлгээ хийсэн баг, үнэлгээний арга зүй, шалгуур үзүүлэлт бүрийг хангаж буй эсэхийг нотлох баримт, тавьсан зорилгодоо хүрч буй эсэх талаарх дүн, дүгнэлт, үйл ажиллагааны давуу болон сул тал, үйлчилгээний чанарт гарсан ахиц, өөрчлөлт, хүндрэл бэрхшээл, цаашид байгууллагын менежмент, багшлах, суралцах үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулахад нэн тэргүүнд анхаарах асуудлын талаар тус тус тусгана.

5.3. Өөрийн үнэлгээний баг үнэлгээний дүн, дүгнэлтээ сургалтын байгууллагын захирагааны зөвлөлийн хуралд жил бүрийн 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор танилцуулж, цэцэрлэг, сургуулийн удирдлагад хүлээлгэн өгнө.

5.3.1. Сургалтын байгууллагын удирдлага үнэлгээний дүн, дүгнэлтийг цэцэрлэг, сургуулийн зөвлөл, багш нарын зөвлөл болон суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчид жил бүрийн 9 дүгээр сарын 5-ны өдрийн дотор танилцуулна.

5.3.2. Өөрийн үнэлгээний тайлан нь цэцэрлэг, сургуулийн тухайн оны үйл ажиллагааны тайлангийн салшгүй хэсэг байна.

5.4. Хөндлөнгийн үнэлгээний баг нь цэцэрлэг, сургуулийн үйлчилгээний чанар, үр дүнд өгсөн үнэлгээ, дүгнэлтийг үнэлгээний ажил дууссанаас хойш ажлын 10 хоногийн дотор аймаг, нийслэлийн боловсролын газрын арга зүйн зөвлөлд танилцуулна.

5.4.1. Хөндлөнгийн үнэлгээний дүн, дүгнэлтийг сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх ажлыг аймаг, нийслэлийн боловсролын газар хариуцна.

5.4.2. Хөндлөнгийн үнэлгээгээр өөрийн үнэлгээний дүн, дүгнэлт бодит бус болох нь нотлогдох тохиолдолд аймаг, нийслэлийн боловсролын газраас тухайн цэцэрлэг, сургуульд өөрийн үнэлгээ дахин хийх чиглэл өгнө.

**Зургаа. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг
сайжруулах төлөвлөгөө боловсруулах**

6.1 Цэцэрлэг, сургуулийн удирдлага өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүнг байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад ашиглана.

6.2 Үнэлгээний дүн, дүгнэлтээр цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаанд нэн тэргүүнд сайжруулах шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг хамарсан төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтүүлнэ.

6.3 Энэ журмын 6.2-т заасан төлөвлөгөөг багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой боловсруулж хэрэгжүүлнэ.

6.4 Хөндлөнгийн үнэлгээний ажил эхлэхийн өмнө сүүлийн 2-3 жилийн өөрийн үнэлгээний үр дүнд боловсруулсан байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, хамт олонд тайлагнах ажлыг цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал хариуцна.

6.5 Цэцэрлэг, сургууль нь үнэлгээний үр дүнд тулгуурлан байгууллага хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө, дотоод журам болон холбогдох бусад дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой зохион байгуулна.

6.6 Хөндлөнгийн үнэлгээний дүн, дүгнэлтэд үндэслэн тухайн цэцэрлэг, сургуульд зөвлөн туслах ажлыг аймаг, нийслэлийн боловсролын газар хариуцна.

Долоо. Бусад

7.1. Хөндлөнгийн үнэлгээ хийхтэй холбогдох зардлыг аймаг, нийслэлийн боловсролын газар хариуцна.

7.2. Хөндлөнгийн үнэлгээний дүнгээр цэцэрлэг, сургуулийг эрэмбэлэх, байр эзлүүлэхийг хориглоно.

7.3. Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулсантай холбогдох баримт бичгийг хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивт хадгална.

Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын
сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журмын
нэгдүгээр хавсралт

ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Чиглэл	Үзүүлэлт	Шалгуур	Оноо (0,1,2,3)
1. Байгууллагын менежмент, удирдлагын манлайлал /30оноо/	1.1 Байгууллагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн	1.1.1 Байгууллагын үнэт зүйл, эрхэм зорилгыг сургуулийн өмнөх насны хүүхдийн эрэлт хэрэгцээг харгалzan бодитой тодорхойлж, хэрэгжилтийг ханган, үнэлгээ хийдэг байдал	1-3
		1.1.2 Цэцэрлэг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны төлөвлөлтийг үнэт зүйл, эрхэм зорилготой уялдуулан, нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн, хэрэгжихүйц байдлаар тодорхойлон боловсруулж, хэрэгжилтэд үнэлгээ хийж, дүгнэсэн байдал	1-3
		1.1.3 Тухайн хичээлийн жилийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөг урт, дунд, богино хугацааны төлөвлөлтэд нийцүүлэн хүүхэд, эцэг эх, багш, ажилтны хэрэгцээ, шаардлагыг тооцон боловсруулж, хэрэгжүүлэн, тухай бүр дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцон ажиллаж буй байдал	1-3
		1.1.4 Цэцэрлэгийн үйл ажиллагааг зохицуулж байгаа дүрэм, журмыг хамтын оролцоотой боловсруулж, хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт хийж ажилладаг байдал	1-3
		1.1.5 Цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагааны тогтвортой байдал, ажлын үр дүн	1-3
	1.2 Удирдлагын манлайлал	1.2.1 Байгууллагын удирдах ажилтны мэдлэг, ур чадвар, арга барил нь багшахуй болон суралцахуйд амжилт гаргахад нөлөөлдөг, хамт олныг багийн манлайлалд уриалан чиглүүлдэг байдал	1-3
		1.2.2 Эрхлэгч, арга зүйч нь байгууллагын үйл ажиллагааны үр дүнд дүн шинжилгээ хийж, чанар үр нөлөөг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгийг багш ажилтанд өгч ажилладаг байдал	1-3
		1.2.3 Цэцэрлэгийн удирдлага нь ёс зүйн хэм хэмжээг мөрдэж, ажлын арга барил, уг хэллэг, харилцаа, хандлага, биеэр үлгэрлэн манлайлдаг байдал	1-3
		1.2.4 Байгууллагын соёл төлөвшүүлэх, хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх талаар цэцэрлэгийн удирдлагын зүгээс төлөвлөн хэрэгжүүлж буй ажил, үр дүн	1-3
	1.3 Төсөв, санхүүгийн менежмент	1.3.1 Төсөв санхүүгийн төлөвлөлт, зарцуулалт нь эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтанд ил тод, нээлттэй байдал	1-3
		1.3.2 Батлагдсан төсөв, үйл ажиллагааны орлого, хандив тусламж, цэцэрлэг хөгжүүлэх сангийн хөрөнгийг үр өгөөжтэй зарцуулсан байдал	
2. Хүний нөөцийн менежмент /27 оноо/	2. 1 Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт	2.1.1 Хүний нөөцийн хэтийн болон дунд хугацааны бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үр дунд хийсэн дүн шинжилгээ	1-3
		2.1.2 Багш, ажилтныг албан тушаалд томилох, чөлөөлөхөд хууль, журмыг баримталдаг, сонгон шалгаруулах үйл ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулсан байдал	1-3
		2.1.3 Багш, ажилтныг тогтворт суурьшилтай ажиллах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, мэргэжлийн багшийн хангамж	1-3

		2.1.4	Багш ажилтнуудад албан тушаалын зорилго, зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэх орчин нөхцөлийг хангасан байдал, тэдний эрүүл мэндийг дэмжсэн, ажлын ачааллыг зохицуулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн	1-3
		2.1.5	Багш, ажилтны ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж буй арга хэлбэр нь хамт олныг хөгжүүлэх, ажлын чанар үр дүнг сайжруулахад чиглэсэн байдал түүний хэрэгжилт үр дүн	1-3
	2.2 Багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжил, ёс зүй	2.2.1	Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааг тэдний хөгжих хэрэгцээний судалгаанд үндэслэн төлөвлөж, хэрэгжүүлдэг байдал, үр дүн	1-3
		2.2.2	Багш, ажилтан ажлын байран дээр мэргэжил дээшлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж, хамтран суралцах, харилцан туршлага солилцох, бие даан мэргэжил дээшлүүлэхэд дэмжих арга хэлбэрийг ашиглан үр дүнд хүрсэн байдал	1-3
		2.2.3	Мэргэжил дээшлүүлэх сургалтын үзэл санааг түгээн дэлгэрүүлэх тогтолцоо бүрдүүлж, үр дүн нь сургалтын чанар, ажил үйлчилгээнд хэрхэн нөлөөлж буйд дүн шинжилгээ хийж буй байдал	1-3
		2.2.4	Сургалтын орчинд багш, ажилтнууд ёс суртахууны хэм хэмжээг сахин, ёс зүйн дүрмийг баримтлан ажиллаж буй байдал	1-3
		3.1 Өдрийн дэглэмийн төлөвлөлт, хэрэгжилт	3.1.1 Өдрийн дэглэмийг цэцэрлэг, хүүхдийн нас, хөгжлийн онцлогт нийцүүлэн, улирал цаг уурын нөхцөлийг харгалzan уян хатан, үйл ажиллагааг хоорондын уялдааг хангаж төлөвлөсөн байдал	1-3
	3.2 Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт	3.1.2	Өдрийн дэглэмийг цагийн хуваарийн дагуу мөрдөж хэвшсэн эсэх, түүнд хяналт тавьж хэрэгжилтийг хангаж буй байдал	1-3
		3.2.1	Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, үнэлэхэд Заах аргын нэгдэл, багш нар хамтран багийн зарчмаар ажиллаж хэвшсэн байдал	1-3
		3.2.2	Багшийн арга зүйн сан бүрдүүлж, баяжуулан хичээл, хөгжүүлэх үйл ажиллагаандаа хэрэглэдэг байдал	1-3
		3.2.3	Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн онцлог, хэрэгцээ сонирхлыг харгалzan, адил тэгш оролцоог ханган төлөвлөж, үр дүнтэй хэрэгжүүлж буй байдал	1-3
		3.2.4	Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг сургалтын олон хэлбэрээр төлөвлөн хэрэгжүүлж буй байдал	1-3
		3.2.5	Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны зорилго нь нийгэмшигүйн хөгжлийг дэмжсэн, уламжлалт ёс заншил, эх оронч үзэл хандлагатай бие хүнийг төлөвшүүлэхэд чиглэсэн байдал	1-3
		3.2.6	Хүүхдийн гүйцэтгэх үйл, дасгал даалгавар нь хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны зорилготой нийцэж буй байдал	1-3
		3.2.7	Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн бэрхшээлийн онцлогт нийцсэн орчинг бүрдүүлж, тэдэнд үзүүлэх дэмжлэгийг хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтэд тусган хэрэгжүүлж буй байдал	1-3
		3.2.8	Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлж, дүгнэн түүнд үндэслэн төлөвлөлтийг сайжруулж буй байдал	1-3
3. Сургалтын хөтөлбөрийн менежмент /66 оноо/				

		3.3.1	Анги танхимд багш-хүүхэд, хүүхэд-хүүхдийн нээлттэй, хүндэтгэлтэй харилцааг эрхэмлэж буй байдал	1-3
		3.3.2	Багшийн арга зүй нь хүүхдийн мэдэх, хийж бүтээх оролдлогыг дэмжсэн, эрэл хайгуул хийлгэсэн, алдаа дээрээ суралцах боломж олгосон байдал	1-3
	3.3 Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалт	3.3.3	Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг нээлттэй чөлөөтэй, сонирхолтойгоор зохион байгуулж, хүүхэд бүрийн оролцоог дэмжиж буй байдал	1-3
		3.3.4	Багш хүүхдийн зөв үйлийг дэмжиж, буруу үйлийг засаж, нөхцөл байдалд тохируулан эерэг хариу мэдээлэл өгч буй байдал	1-3
		3.3.5	Дасгал даалгавар, энгийн туршилтыг өмнөх мэдлэг, бодит амьдрал, хэрэглээтэй холбож буй байдал	1-3
		3.3.6	Хүүхэд бусадтай хамтран ажиллах, дасгал даалгавар гүйцэтгэх явцад бусдыг хүндэтгэх, туслах, хүлээнтэй хандах, дүрэм журмыг биелүүлэх, сэтгэл хөдлөлөө зохицуулах зэрэг үйлийг дэмжиж буй байдал	1-3
		3.3.7	Сургалтын хэрэглэгдэхүүн нь хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны агуулгад нийцсэн, хүртээмжтэй, хүүхэд бүрд сонголт хийх боломж олгосон байдал	1-3
		3.4.1	Үнэлгээний арга, хэрэгслийг ашиглан хүүхдийн суралцах арга барилын онцлог, хандлага зэргийн бодит байдлыг илрүүлж дүн шинжилгээ хийж баримтжуулж буй байдал	1-3
		3.4.2	Явцын үнэлгээнд тулгуурлан үр дүнгийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргасан байдал	1-3
	3.4 Хүүхдийн хөгжлийн үнэлгээ, үр дүнд хийсэн шинжилгээ	3.4.3	Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдалд үнэлгээ хийж, сургуулийн бага ангийн багш нартай хамтран ажиллаж буй байдал	1-3
		3.4.4	Хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх дугуйлан болон бусад үйл ажиллагааг зохион байгуулж, гарсан үр дүнг хүүхдийн хөгжлийн үнэлгээнд харгалзан тооцдог байдал	1-3
		3.4.5	Хүүхдийн хөгжил, төлөвшлийн онцлог ялгаатай байдлыг илрүүлэх, үнэлэх, ажлын талаар эцэг эхэд мэдээлэл өгөх, хамтран ажиллахдаа хүүхдийн эрхийг дээдэлдэг байдал	1-3
4. Сургалтын орчин, үйлчилгээ хүүхдэд ээлтэй байдал /30 оноо/	4.1 Хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг	4.1.1	Хүүхдэд эрүүл ахуйн дадал хэвшил олгох, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж буй ажил, түүний үр дүнг тооцдог байдал	1-3
		4.1.2	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, усан хангамжийн эрүүл ахуйн шаардлага хангасан орчныг бүрдүүлж, чанар, аюулгүй байдалд хяналтыг тогтмол хийж, үр дүнг тооцдог байдал	1-3
		4.1.3	Хүүхэд хамгааллын бодлогыг үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлж буй байдал, үр дүн	1-3
		4.1.4	Цэцэрлэгт шинээр элссэн болон сургуульд элсэн суралцах хүүхдийг шинэ орчин, үйл ажиллагаанд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж буй байдал, үр дүн	1-3

		4.2.1	Гадна орчин дахь эд зүйлс, биесийн тамир, тоглоомын талбайг хүүхдэд ээлтэй, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн байдлаар өнгө үзэмжтэй, аюулгүй, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материал ашиглан хийсэн, байгаль экологид ээлтэй, орчны стандартын шаардлагыг хэрэгжүүлж буй байдал	1-3
		4.2.2	Барилга байгууламж, бүлгийн өрөө, ариун цэврийн өрөө, хөгжим, биесийн тамирын танхим, гал тогоонд тавигдах стандарт шаардлагыг хэрэгжүүлж буй байдал	1-3
	4.2 Орчны аюулгүй байдал	4.2.3	Бүлгийн сургалтын төв дэх хэрэгсэл, тоглоом нь хүртээмжтэй, хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон, олон хувилбартай, сонголттой, орчны стандартын шаардлагыг хэрэгжүүлж буй байдал	1-3
		4.2.4	Галын аюулгүй байдал, ариун цэврийн байгууламж, хүүхэд тээвэрлэх тээврийн хэрэгсэл, гэр цэцэрлэгийн аюулгүй байдлыг хангаж буй байдал	1-3
		4.2.5	Онцгой байдал, гамшиг осол, аюулт үзэгдэл болох үед авах хариу арга хэмжээ, ажлын горим, орчин нөхцөлийг бүрдүүлсэн байдал	1-3
		4.2.6	Орчны аюулгүй байдалд байнгын хяналт үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээг тогтмол хийдэг, энэ талаар хэрэгжүүлсэн ажлын үр дүн	1-3
5. Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо/ түншлэл/18 оноо/	5.1 Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн хамтын ажиллагаа	5.1.1	Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн сэтгэл ханамжийг тандан судалж, сургалт, хөгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг төлөвлөж хэрэгжүүлэхэд тэдний саналыг тусган шийдвэрлэсэн байдал	1-3
		5.1.2	Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн хөгжил, төлөвшил, хамгааллын талаар хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой болгож, байнгын оролцоог хангасан байдал	1-3
		5.1.3	Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд цэцэрлэгийн үйл ажиллагаа, орчинтой танилцах, хяналт тавих, мэдээлэл авах боломжийг хангасан байдал	1-3
		5.1.4	Эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдийн хөгжлийн талаарх мэдлэг, чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байдал	1-3
	5.2 Нийгмийн түншлэл	5.2.1	Олон нийтийн байгууллага болон гэрээт байгууллагатай түншлэн ажилладаг байдал, нийгэмд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаа, үр дүн	1-3
		5.2.2	Цэцэрлэгийн орчин, үйл ажиллагааг сайжруулахад орон нутгийн захираганы болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн дэмжлэг, түүний үр дүн, хариу тайлагнадаг байдал	1-3
Авбал зохих нийт оноо				174

Хүүхдийн цэцэрлэг, өрөнхий боловсролын сургуулийн уйл ажиллагааг үнэлэх журмын хоёрдугаар хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН УЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Чиглэл	Үзүүлэлт	Шалгуур	Оноо (0,1,2,3)
1. Байгууллагын менежмент, удирдлагын манлайлал /36 оноо/	1.1 Байгууллагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн	1.1.1 Сургуулийн үнэт зүйл, эрхэм зорилгыг оролцогч талуудын оролцоотой бодитой тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулж, үнэлгээ хийдэг байдал	0-3
		1.1.2 Сургууль хөгжүүлэх урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлтийг нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн, байгууллагын үнэт зүйл, эрхэм зорилготой уялдуулан хэрэгжихүйц байдлаар боловсруулсан, хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт хийсэн байдал	0-3
		1.1.3 Хичээлийн жилийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөг багш, ажилтан болон үйлчлүүлэгчийн хэрэгцээ, шаардлага, хүлээлтийг тооцож боловсруулсан, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээ авсан байдал	0-3
		1.1.4 Сургуулийн үйл ажиллагааг зохицуулж байгаа дүрэм, журмыг хамтын оролцоотой боловсруулсан, тэдгээрийн хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт хийж ажилладаг байдал	0-3
	1.2. Удирдлагын манлайлал	1.2.1 Багшахуй болон суралцахуйд амжилт гаргахад нөлөөлөхүйц мэдлэг, үр чадвар, туршлага бүхий сургуулийн захирал, удирдлагын баг сургуулийг удирдаж байгаа эсэх	0-3
		1.2.2 Бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргах үйл ажиллагаанд багш, ажилтан, суралцагч, олон нийтийн оролцоог хангахад удирдлагын багаас хэрэгжүүлдэг арга хэмжээ, үр дүн	0-3
		1.2.3 Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, багшах болон суралцахуйд ажиллагааны чанар, үр нөлөөг сайжруулахад сургуулийн захирал, сургалтын менежерийн оролцоо, багшид үзүүлж буй дэмжлэг, туслалцаа, үр дүн	0-3
		1.2.4 Сургуулийн захирал, удирдлагын багаас хүүхдийн суралцахуйд ажиллагааны чанар, үр нөлөөг сайжруулахад сургуулийн захирал, сургалтын менежерийн оролцоо, багшид үзүүлж буй дэмжлэг, туслалцаа, үр дүн	0-3
		1.2.5 Байгууллагын соёл төлөвшүүлэх, хамт олны зөвхөн суралцахуйд ажиллагааны чанар, үр нөлөөг сайжруулахад сургуулийн захирал, сургалтын менежерээс төлөвлөн хэрэгжүүлдэг ажил, үр дүн	0-3
		1.2.6 Сургуулийн удирдлага нь ёс зүйн хэм хэмжээг мөрдэж, ажлын арга барил, уг хэллэг, харилцаа, хандлага, биеэр үлгэрлэн манлайлдаг байдал	0-3
	1.3. Төсөв, санхүүгийн менежмент	1.3.1 Батлагдсан төсөв, өөрийн үйл ажиллагааны орлого, хандив, тусламж, сургууль хөгжүүлэх сангийн хөрөнгө, түүний зарцуулалт, үр өгөөжтэй байдал	0-3
		1.3.2 Батлагдсан төсөв, өөрийн үйл ажиллагааны орлого, хандив, тусламж, сургууль хөгжүүлэх сангийн хөрөнгө, түүний зарцуулалт болон санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг ил тод, нээлттэй мэдээлдэг байдал	0-3

2. Хүний нөөцийн менежмент /30 очоо/	2.1. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт	2.1.1	Хүний нөөцийн хэтийн болон дунд хугацааны бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилт, үр дунд хийсэн шинжилгээ	0-3
		2.1.2	Багш, ажилтны албан тушаалд томилох, чөлөөлөхөд баримталдаг зарчим, тавих шаардлага, шалгуур үзүүлэлт, тэдгээрийн хэрэгжилт, сонгон шалгаруулах үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	0-3
		2.1.3	Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхи бүхий мэргэжлийн багшаар хангагдсан байдал	0-3
		2.1.4	Шинээр томилогдсон багш, ажилтныг ажлын байранд нь дасан зохицоход туслах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлдэг үйл ажиллагаа, үр дүн	0-3
		2.1.5	Багш, ажилтны тогтвортой байдал /сүүлийн 3 жилд шилжилт хөдөлгөөнд орсон багш, ажилтны тоо, шалтгаан/	0-3
	2.2. Багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжил, ёс зүй	2.2.1	Сургалтын хөтөлбөр болон багшийн хэрэгцээг тооцон багш, ажилтны мэдлэг, боловсрол, үр чадварыг ажлын байранд нь дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаа, түүний залгамж чанар, үр нөлөөнд хийсэн дүн шинжилгээ	0-3
		2.2.2	Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг тооцсон байдал	0-3
		2.2.3	Мэргэжил дээшлүүлэх төвлөрсөн сургалтад оролцогч сургалтын үр дүнг бусдад түгээн дэлгэрүүлэх тогтолцоо бүрдсэн байдал	0-3
		2.2.4	Мэргэжил дээшлүүлэх ажлын үр дүн нь сургалтын чанарт хэрхэн нөлөөлж буйг үнэлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, үр дүн	0-3
		2.2.5	Анги танхимд болон сургуулийн орчинд багш, ажилтан ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, үг хэллэг, харилцаа, хандлага, биеэр үлгэрлэн манлайлдаг байдал	0-3
3. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн /84 очоо/	3.1. Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх менежмент	3.1.1	Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг суралцагчийн суурь, мэдлэг, чадвар, ялгаатай байдал, хэрэгцээ, сонирхлыг харгалzan, адил тэгш оролцоог хангасан байхаар төлөвлөж, үр дүнтэй зохион байгуулдаг байдал	0-3
		3.1.2	Хичээл, сургалтын үйл ажиллагааг заах аргын нэгдэл, тэнхим, багаар хамтран хэлэлцэж, хичээл хоорондын агуулгын залгамж холбоог ханган төлөвлөдөг байдал	0-3
		3.1.3	Сургалтын материал, нөөц, хэрэглэгдэхүүнийг хамтран бэлтгэх, сонгох, орон нутгийн материал, жишээ баримтыг тулхүү ашиглан хичээлийг амьдрал, практик хэрэглээтэй холбон явуулах үйл ажиллагаа тогтмолжсон байдал	0-3
		3.1.4	Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх даалгаврын сантай бүрдүүлсэн, түүний хэрэглээ, сайжруулж, баяжуулдаг байдал	0-3
		3.1.5	Суралцагч эзэмшивэл зохих зүйлээ хугацаандаа эзэмшиж байгаа байдалд хийсэн шинжилгээ, түүний мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн	0-3
	3.2. Хичээл зохион байгуулалт	3.2.1	Багшийн зүгээс бүх суралцагчдад хүндэтгэлтэй хандах уур амьсгал бүрдүүлсэн байдал	0-3
		3.2.2	Жендерээр ялгаварлах хандлага гаргахгүй байх, суралцагчийн зөв үйлийг дэмжиж, буруу үйлийг засаж буй байдал	0-3
		3.2.3	Хичээлийн зорилгыг тодорхой болгон танилцуулж, хичээл дээр хийх үйл ажиллагааг бүрэн ойлгуулж буй байдал	0-3
		3.2.4	Шинжлэх ухааны нэр томьёо, үг хэллэгийг суралцагчийн нас, сэтгэхүйд тохируулан оновчтой, товч, тодорхой сонгон хэрэглэж буй байдал	0-3
		3.2.5	Хичээл дээр ажиллаж буй дасгал, даалгавар, үйл ажиллагаа нь хичээлийн зорилгод нийцсэн байдал	0-3

		3.2.6	Хичээлийн явцад хүүхдийн онцлогийг харгалзсан, хөгжлийн ахицыг дэмжсэн сургалтын идэвхитэй арга хэрэглэж, хамтын оролцоог хангаж буй байдал	0-3
		3.2.7	Суралцах бэрхшээлтэй, сурлагын хоцрогдолтой эсхүл чадварлаг суралцагчийн хэрэгцээг тооцсон ялгаатай арга техник хэрэглэж байдал	0-3
		3.2.8	Дасгал, даалгавар, шийдвэрлэх асуудал, туршилт, дадлага ажлыг өмнөх мэдлэг, бодит амьдрал, хэрэглээтэй холбож буй байдал	0-3
		3.2.9	Бие даан болон бүлгээр ажиллах явцад ажиглалт хийж, ташаа ойлголтыг илрүүлэн нэмэлт тайлбар хийж, шаардлагатай дэмжлэгийг цагт нь үзүүлж буй байдал	0-3
		3.2.10	Суралцагчдад сонголт хийх, өөрийгөө илэрхийлэх, асуух боломж олгох замаар бие даасан байдлыг хөгжүүлж буй байдал	0-3
	3.2. Хичээл зохион байгуулалт	3.2.11	Нээлттэй/задгай хариулт шаардсан асуулт тавих, дүн шинжилгээ хийх дасгал ажиллуулах замаар суралцагчдын эргэцүүлэн бodoх, бүтээлч сэтгэлгээг дэмжиж буй байдал	0-3
		3.2.12	Дасгал, даалгавар, туршилт, дадлага ажлыг хэрхэн гүйцэтгэх зааварчилгааг суралцагчдад ойлгомжтой тайлбарлаж буй байдал	0-3
		3.2.13	Багш суралцагчдын сайн гүйцэтгэлийг олж тогтоон урамшуулж, хандлага, урам зоригийг үнэлдэг	0-3
		3.2.14	Суралцагчид өөрийгөө болон бусдыг үнэлэх, бие биедээ туслах үйлийг дэмжиж буй байдал	0-3
		3.2.15	Суралцагч тухайн агуулгыг ойлгосон эсэхийг богино хугацаанд илрүүлэх арга техникийг оновчтой сонгон хэрэглэж буй байдал	0-3
		3.2.16	Асуудал шийдвэрлэх, хамтран ажиллах явцад бусдын санаа бодлыг хүндэтгэх, сэтгэл хөдлөлөө зохицуулах үйлийг дэмжиж буй байдал	0-3
		3.1.17	Хичээлд хэрэглэж буй технологи, сургалтын хэрэглэгдэхүүн нь хөтөлбөрийн агуулга, суралцагчийн насын онцлогт нийцсэн, суралцах идэвх, сонирхол, бүтээлч үйлийг дэмжсэн байдал	0-3
	3.3. Сурлагын амжилтын үнэлгээ, үр дүнд хийсэн шинжилгээ	3.3.1	Сургуулийн хэмжээнд суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээний агуулга, арга хэлбэр, хугацааг тодорхойлсон нэгдсэн төлөвлөгөө, түүний хэрэгжилт	0-3
		3.3.2	Оношлох, явцын болон эцсийн үнэлгээ /түвшин тогтоох, бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцсийн, анги дэвших болон улсын шалгалт/-ний үр дүнд хийсэн шинжилгээ, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ахиц, өөрчлөлт /хичээл бүрээр/	0-3
		3.3.3	Сургуулийн хэмжээнд тааруу үнэлгээтэй шалгагдсан сэдэв, агуулгыг суралцагчдад бүрэн эзэмшүүлэхэд багш, заах аргын нэгдлээс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, түүний үр дүн	0-3
		3.3.4	Суралцах бэрхшээлтэй суралцагчид нэмэлт тусламж үзүүлэх, тэдний онцлогт тохирсон үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлснээр гарсан ахиц, өөрчлөлт	0-3
		3.3.5	Сурлагын амжилтын өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний сүүлийн 3 жилийн үр дүнд хийсэн шинжилгээ, ахиц өөрчлөлт	0-3
		3.3.6	Мэргэжлийн байгууллагаас хийсэн хөндлөнгийн үнэлгээний дүн /аймаг, нийслэлийн боловсролын газар, Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулдаг чанарын үнэлгээ/, түүнд хийсэн шинжилгээ, авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ, үр нөлөө	0-3

4. Сургалтын орчин, үйлчилгээг хүүхдэд ээлтэй байгах /45 оног/	4.1. Суралцагчдад үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг	4.1.1	Суралцагчдын ирцэд хийсэн шинжилгээ, түүний үр дүнд үндэслэн хичээлд суугаагүй суралцагчдад үзүүлэх үйлчилгээ, үр дүн	0-3
		4.1.2	Сургуулийн номын сангийн үйлчилгээний хүртээмж, зохион байгуулдаг үйл ажиллагаа, үр дүн	0-3
		4.1.3	Суралцагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх үйлчилгээний бэлэн байдал	0-3
		4.1.4	Суралцагчдын авьяасыг хөгжүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа, мэргэжил сонголтод дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	0-3
		4.1.5	Дотуур байранд амьдардаг хүүхдийн суралцагчид сургуулийн орчин, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйлчилгээ, бага ангийн сурагчдад асаргаа халамж үзүүлдэг байдал	0-3
		4.1.6	Сургуульд шинээр элссэн болон бага ангиас дунд ангид дэвшин суралцаж буй суралцагчид сургуулийн орчин, сургалтын үйл ажиллагаанд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байдал	0-3
		4.1.7	Шилжин ирсэн суралцагчдад сургуулийн орчин, үйл ажиллагаанд мөрддөг дүрэм, журам болон аюулгүй ажиллагааны заавар танилцуулах, дасан зохицоход дэмжлэг үзүүлэх зохион байгуулалттай арга хэмжээ явагддаг байдал	0-3
		4.1.8	Суралцагч бүрт чиглэсэн хувийн дэмжлэг, зөвлөгөө үзүүлдэг, санал бодлыг нь сонсож хариу арга хэмжээ авдаг байдал	0-3
		4.1.9	Сургуулийн орчинд суралцагчид бие биенээ ялгаварлан гадуурхах, дээрэлхэх, дарамтлах зэрэг үйлдэл гарахын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн	0-3
4.2. Сургалтын орчны аюулгүй байдал	4.2. Сургалтын орчны аюулгүй байдал	4.2.1	Сургалтын орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах "Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын ерөнхий шаардлага MNS 6782:2019", "Дотуур байрын орчин, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага MNS 6781:2019", "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрын орчны эрүүл ахуйн ерөнхий шаардлага" стандартын хэрэгжилт	0-3
		4.2.2	Сургалтын орчны аюулгүй байдал, ус, ариун цэврийн байгууламж, үйлчилгээнд үзлэг, шалгалтыг давтамжтай хийх нэгдсэн график, түүний хэрэгжилт, үзлэг, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ	0-3
		4.2.3	Онцгой нэхцэл байдал үүссэн үед ажиллах ажлын горим, галын болон аюулгүйн нэхцэл байдлыг хангаж буй байдал	0-3
		4.2.4	Суралцагчдын сургуульд ирэх, буцах үеийн аюулгүй байдлыг хангах талаар хийж буй ажлын үр дүн	0-3
		4.2.5	Хүүхдийн хоол, хүнсний аюулгүй байдал тавих хяналтын систем, авч хэрэгжүүлдэг арга хэмжээ, гарсан зөрчил, шийдвэрлэлт	0-3
		4.2.6	Сургалтад технологи, сургалтын техник хэрэгсэл, бусад нөөцийг ашиглах боломж бүрдсэн байдал, ашиглалт	0-3

5.	Эцэг эх, олон нийтийн оролцоо, түншлэл /21 онoo/	<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="width: 15%; vertical-align: top;">5.1. Эцэг, эх, олон нийтийн хамтын ажиллагаа</td><td style="width: 65%; vertical-align: top;"> <p>5.1.1 Хүүхдийн сурах, хөгжих үйлийг дэмжих чиглэлээр эцэг эх, асран хамгаалагч болон олон нийттэй үр дүнтэй харилцаа тогтоосон байдал</p> <p>5.1.2 Эцэг эх, асран хамгаалагч болон олон нийтийн санал бодлыг сонсох, харилцах албан ёсны арга хэлбэр, санал, хүсэлт, гомдлын мөрөөр арга хэмжээ хэрэгжүүлэн, үр дүнг тайлагнадаг байдал</p> <p>5.1.3 Хүүхдийн хөгжил, төлөвшил, суралцах үйл явц, ахиц, амжилтын талаар эцэг эх, асран хамгаалагчдад сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгөх хуваарь, түүний хэрэгжилтийн байдал</p> <p>5.1.4 Эцэг, эх, асран хамгаалагч, олон нийт сургуулийн орчин, үйл ажиллагаатай танилцах, хяналт тавих, мэдээлэл авах боломжийг хангасан байдал</p> </td><td style="width: 10%; vertical-align: top; text-align: center;">0-3</td></tr> <tr> <td style="vertical-align: top;">5.2. Нийгмийн түншлэл</td><td style="vertical-align: top;"> <p>5.2.1 Сургуулийн орчин, үйл ажиллагааг сайжруулахад орон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн холбоо, иргэдийн дэмжлэг, түүний үр дүн</p> <p>5.2.2 Гэрээт байгуулагатай хэрхэн түншлэн ажилладаг, түүний үр дүн</p> <p>5.2.3 Сургуулийн хамт олноос зохион байгуулж буй нийгэмд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаа, үр дүн</p> </td><td style="vertical-align: top; text-align: center;">0-3</td></tr> </table>	5.1. Эцэг, эх, олон нийтийн хамтын ажиллагаа	<p>5.1.1 Хүүхдийн сурах, хөгжих үйлийг дэмжих чиглэлээр эцэг эх, асран хамгаалагч болон олон нийттэй үр дүнтэй харилцаа тогтоосон байдал</p> <p>5.1.2 Эцэг эх, асран хамгаалагч болон олон нийтийн санал бодлыг сонсох, харилцах албан ёсны арга хэлбэр, санал, хүсэлт, гомдлын мөрөөр арга хэмжээ хэрэгжүүлэн, үр дүнг тайлагнадаг байдал</p> <p>5.1.3 Хүүхдийн хөгжил, төлөвшил, суралцах үйл явц, ахиц, амжилтын талаар эцэг эх, асран хамгаалагчдад сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгөх хуваарь, түүний хэрэгжилтийн байдал</p> <p>5.1.4 Эцэг, эх, асран хамгаалагч, олон нийт сургуулийн орчин, үйл ажиллагаатай танилцах, хяналт тавих, мэдээлэл авах боломжийг хангасан байдал</p>	0-3	5.2. Нийгмийн түншлэл	<p>5.2.1 Сургуулийн орчин, үйл ажиллагааг сайжруулахад орон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн холбоо, иргэдийн дэмжлэг, түүний үр дүн</p> <p>5.2.2 Гэрээт байгуулагатай хэрхэн түншлэн ажилладаг, түүний үр дүн</p> <p>5.2.3 Сургуулийн хамт олноос зохион байгуулж буй нийгэмд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаа, үр дүн</p>	0-3
5.1. Эцэг, эх, олон нийтийн хамтын ажиллагаа	<p>5.1.1 Хүүхдийн сурах, хөгжих үйлийг дэмжих чиглэлээр эцэг эх, асран хамгаалагч болон олон нийттэй үр дүнтэй харилцаа тогтоосон байдал</p> <p>5.1.2 Эцэг эх, асран хамгаалагч болон олон нийтийн санал бодлыг сонсох, харилцах албан ёсны арга хэлбэр, санал, хүсэлт, гомдлын мөрөөр арга хэмжээ хэрэгжүүлэн, үр дүнг тайлагнадаг байдал</p> <p>5.1.3 Хүүхдийн хөгжил, төлөвшил, суралцах үйл явц, ахиц, амжилтын талаар эцэг эх, асран хамгаалагчдад сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгөх хуваарь, түүний хэрэгжилтийн байдал</p> <p>5.1.4 Эцэг, эх, асран хамгаалагч, олон нийт сургуулийн орчин, үйл ажиллагаатай танилцах, хяналт тавих, мэдээлэл авах боломжийг хангасан байдал</p>	0-3						
5.2. Нийгмийн түншлэл	<p>5.2.1 Сургуулийн орчин, үйл ажиллагааг сайжруулахад орон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн холбоо, иргэдийн дэмжлэг, түүний үр дүн</p> <p>5.2.2 Гэрээт байгуулагатай хэрхэн түншлэн ажилладаг, түүний үр дүн</p> <p>5.2.3 Сургуулийн хамт олноос зохион байгуулж буй нийгэмд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаа, үр дүн</p>	0-3						
Авбал зохих нийт оноо		216						

... 0 0 0 ...